



**БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ**

**2025 ОНЫ 04 ДҮГЭЭР
САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

СӨҮЛ ХОТ

2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр

Тайлант хугацаанд чиг үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг явуулж ажилласан.

- I. АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ
- II. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
- III. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ

I. АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ

1. БНСУ-д Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдэд дэмжлэг үзүүлэх, мэдээллийн санд баяжилт хийх арга хэмжээ

1.1.1 Хөдөлмөрийн гэрээт ажилчны Е-9 визээс ур чадвартай ажиллах хүчний Е-7-4 виз рүү шилжсэн иргэдийн судалгаанд тайлант хугацаанд 7 иргэнийг, тус виз рүү шилжих хүсэлтэй болон хугацааны болзол хангасан иргэдийн судалгаанд 5 иргэнийг шинээр бүртгэж, нийт 9 иргэнд оноо тоолох, гэр бүлээ урих, хэлний шалгалт сургалтад бүртгүүлэх, визний ангиллаа дараагийн ангилал руу өөрчлөх зэрэг мэдээлэл зөвлөгөө өгч, виз мэдүүлэгт нь дэмжлэг үзүүлсэн.

1.1.2 БНСУ-д оршин суугаа Монгол Улсын иргэдийн цахим мэдээллийн сангийн хөгжүүлэлтийн ажлын даалгаврын саналыг болон тус улсад ажиллаж буй гэрээт ажилчдын дэлгэрэнгүй дата мэдээллийг тус тус албан бичгээр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлсэн.

2. Хөдөлмөрийн гэрээт иргэдийг хууль бусаар оршин суухаас сэргийлэх, хугацаандаа нутаг буцахад шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх

1.2.1 Хөдөлмөрийн гэрээ дуусах дөхөж байгаа хөдөлмөрийн гэрээт 92 иргэдэд хууль бусаар оршин суухаас сэргийлэх чиглэлээр масс мессеж илгээсэн.

3. БНСУ-д оршин сууж байгаа монгол иргэд, гэр бүл, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг шинэчлэх, сэтгэл зүйн тулгамдсан асуудлаар үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ

1.3.1 Тайлант хугацаанд сэтгэл зүйн зөвлөгөө, ганцаарчилсан сэтгэл засал нийт 35 хүнд хийж, сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн. Үүнээс нойрны өөрчлөлтийн асуудлаар 15 иргэнд, сэтгэл түгшилтийн асуудлаар 12 иргэнд, сэтгэл гутралын асуудлаар 5 иргэнд, гэр бүлийн асуудлаар 3 иргэнд зөвлөгөө өгсөн.

1.3.2 Нийгмийн хамгааллын үйлчилгээний ажлын хүрээнд БНСУ-д хууль бусаар ажиллаж амьдарч буй иргэдийг эмнэлгийн үзлэг болон эрүүл мэндийн даатгалд хамруулах зорилгоор “JUBILEE” эрүүл мэндийн сайн дурын сантай хамтран ажиллаж 2025 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр тус төвөөр дамжуулан хүсэлт гаргасан 6 иргэнийг 505,000 воны эмчилгээ үйлчилгээнд үнэ төлбөргүй хамруулан орчуулгын үйлчилгээ үзүүлсэн.

II. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

1. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа болон бусад хэлбэрээр ажиллаж, амьдарч байгаа иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар хамруулах нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх арга хэмжээ

2.1.1 БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдээс Монгол Улсын нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд албан журмаар 34 иргэнийг хамруулж, холбогдох программд мэдээллийг бүртгэн гэрээ байгуулсан. Мөн Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээний хугацааг сунгаж 25 иргэн, гэж үрэгдүүлэн дахин авах хүсэлт гаргасан 10 иргэн, шинээр чөлөөлөгдөх гэрчилгээг 38 иргэн буюу нийт 73 иргэнд тус тус олгосон.

2.1.2 БНСУ-д хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн визний ангиллаар оршин сууж буй Монгол Улсын 45 иргэнийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулан, холбогдох программд мэдээллийг бүртгэж гэрээ байгуулсан. Мөн Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээний хугацааг сунгаж 28 иргэн, гэж үрэгдүүлэн дахин авах хүсэлт гаргасан 1 иргэн, шинээр чөлөөлөгдөх гэрчилгээг 45 иргэн буюу нийт 74 иргэнд тус тус олгосон.

2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, тайлагнах арга хэмжээ

2.2.1 Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны А/01 дугаар тушаалаар тус тасгийн 2025 оны орлогын батлагдсан төлөвлөгөө 5,031,634,000.00 төгрөг, сар бүрийн орлогын төлөвлөгөө 419,302,833.33 төгрөг болно. Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 58 хувиар биелүүлсэн.

Хүснэгт 1: Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төвлөрүүлэлт

Сар	Сарын орлогын төлөвлөгөө /төгрөгөөр/	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого		Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого	Нийт төвлөрүүлсэн шимтгэлийн орлого		Биелэлтийн хувь	Тухайн сарын МБ-ны эхний өдрийн хаалтын ханш
		Вон	Төгрөг	Төгрөг	Вон	Төгрөг		
4	419,302,833.33	35,890,000.00	85,059,300.00	160,126,390.00	35,890,000.00	245,185,690.00	58	2.37

2.2.2 Тайлант хугацаанд 105,351,654.75 төгрөгийн шимтгэлийн орлогыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Төрийн сангийн дансанд төвлөрүүлэн, сарын мэдээг заасан хугацаанд гаргаж, мөн “Нийгмийн даатгалын ерөнхий хууль” болон “Шилэн дансны хууль”-д заасны дагуу Сангийн яамны холбогдох мэдээллийн санд байршуулсан.

III. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ

1. БНСУ-д амьдарч буй иргэд болон хөдөлмөрийн гэрээт иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, өргөдөл гомдлыг шийдвэрлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1.1 БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирэх 24 иргэнд ирэхээс өмнөх сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр цахимаар, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хөгжлийн сангийн Ёжү хот дахь Олон улсын сургалтын төв, Инчон, Ичон хот дахь сургалтын төвүүдэд 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр 21 гэрээт иргэн, 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр 5 иргэнийг хамруулан ирсний дараах сургалтыг танхимаар тус тус зохион байгуулж, дараах агуулгын хүрээнд мэдээлэл өгөв. Үүнд:

- ХНХҮТ-ийн үйл ажиллагааны танилцуулга
- Цалин хөлс тооцох, ажлын байр солих талаар
- Үйлдвэрлэлийн ослын даатгал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ослоос урьдчилан сэргийлэх тухай
- Солонгос Улсын хууль, журам, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар
- Суугаа орондоо дасан зохицоход анхаарах зүйл
- Сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл
- Ур чадвартай ажиллах хүч E-7-4 визний талаар
- Солонгос хэлний сургалт, урьдчилсан үнэлгээ хийх шалгалтуудын хуваарь
- Хууль бусаар оршин суухын сөрөг тал, хуулийн дагуу оршин суухын давуу тал гэх мэт.

Түүнчлэн сэрээт машин жолоодох эрх олгох сургалтын бүртгэлийг зохион байгуулж, бүртгүүлсэн 75 иргэний материалыг сургалт зохион байгуулах байгууллагад илгээсэн.

3.1.2 Тайлант хугацаанд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах, Солонгос Улсын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, ажил олгогч эзэд болон холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх зэргээр утас, цахим, танхимаар нийт 811 удаагийн үйлчилгээг үзүүлсэн.

Хүснэгт 2: Үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо

Үйлчилгээ үзүүлсэн тоо	Утсаар	679
	Цахимаар	50
	Танхимаар	82
	Нийт	811

БНСУ-д оршин сууж буй иргэдэд хөдөлмөрийн харилцаатай холбоотой өргөдлийг хүлээн авч, Самсунг даатгалын оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал, үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү, нутаг буцах зардал, үйлдвэрлэлийн ослын даатгал, олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс зэрэгтэй холбоотой өргөдөл гомдол хүлээн авч, нийт 16 иргэний **63,950,738.00** воныг олгуулсан бөгөөд одоогийн байдлаар 20 өргөдөл гомдол шийдвэрлэх шатанд явагдаж байна.

Хүснэгт 3: Ажил үйлчилгээний төрлөөр иргэдэд олгуулсан нийт мөнгөн дүнгийн жагсаалт

Ажил үйлчилгээний төрөл		Мөнгөн дүн /вон/
Хөдөлмөрийн гэрээт ажилчид	Нутаг буцах замын зардал	2,562,460.00
	Цалин, илүү цагийн хөлс	5,674,723.00
	Самсунгийн 13 дахь сарын цалин	14,022,430.00
	Үйлдвэрээс авах 13 дахь сарын цалин	23,022,874.00
Бусад төрлийн виз	Олгогдоогүй, хойшлогдсон цалин хөлс	
	Үйлдвэрлэлийн ослын даатгал	
Хууль бусаар оршин суудаг иргэдэд	13 дахь сарын цалин	18,163,251.00
	Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад	505,000.00
НИЙТ ОЛГУУЛСАН ДҮН		63,950,738.00

Хүснэгт 4: Өргөдлийн шийдвэрлэлтийн байдал

Нийт өргөдөл	Өргөдлийн шийдвэрлэлтийн байдал				
	Шинээр хүлээн авсан өргөдөл	Хугацаанд нь шийдвэрлэсэн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн	Шийдвэрлэж буй
41	32	21	4	-	20

Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан болзол нөхцөлийг хангасан 5 даатгуулагчдад тэтгэмжийн тодорхойлолт олгосон.

3.1.3 2025 оны 04 дүгээр сарын 26-ны бямба гарагт Мугпу хот болон тус бүс нутаг орчимд оршин сууж буй Монгол иргэдэд нийгмийн даатгал, сэтгэл зүйн эрүүл мэнд, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар явуулын үйлчилгээг явуулж, зөвлөгөө мэдээлэл хүргэн ажилласан.

3.1.4 Төвийн БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв социал хуудсанд 23 удаа, байгууллагын <https://seoulcenter.misp.gov.mn> цахим хуудсанд 24 удаагийн мэдээлэл, зөвлөгөө нийтэлж сурталчилснаар 293,926 хандалт авсан. Тухайлбал, БНСУ-д ажлын байр хайх сувгуудын мэдээлэл, гадаад ажилчдыг дэмжих төвүүдийн мэдээлэл, оноот системийн E-7-4, E-7-4R визийн онцлог, БНСУ-ын 5 байгууллагын хамтарсан баривчилгаа эхэлсэн тухай, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа, эмнэлгийн үнэ төлбөргүй үзлэг оношилгоо зохион байгуулах тухай, суугаа улсад ажиллаж байхдаа ажлын байран дахь бэлгийн дарамтад өртсөн тохиолдолд авах арга хэмжээний тухай гэх мэт. Түүнчлэн E-7-4 визний асуудлаар “E-7-4 визний мэдээлэл солилцох групп” социал групп үүсгэн визээ сольсон, солих хүсэлтэй иргэдийг нэгтгэж байгаа ба гишүүдийн тоо 117 байна. Мэдээлэл сурталчилгааг идэвхжүүлэх зорилгоор тус социал хуудсанд 4 удаагийн мэдээлэл зөвлөгөөг нийтэлсэн. Гэрээний залуус ТББ-тай хамтран хөдөлмөрийн гэрээт иргэдэд гадаад оронд хэрхэн дасан зохицох тухай видео бичлэг бэлтгэн хүргэв. Төрийн байгууллагуудын нэгдсэн цахим сайт gov.mn-д байгууллагын мэдээ нийтлэлүүдийг нийтлэн, танилцуулга, мэдээллүүдийг шинэчилсэн. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр мэдээлэл бэлтгэн төвийн чатбот-д холбосон.

3.1.5 Нутаг буцаж буй монгол ажилчдыг (E-9, E-7) бичил бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр БНСУ-ын “The Bridge” байгууллагатай уулзалт зохион байгуулав. Тус байгууллага нь нийгэмд эерэг нөлөө үзүүлэх импакт хандивын системийг ашиглан БНСУ-д хөдөлмөр эрхлээд нутаг буцаж буй гадаадын иргэдийг эх орондоо бизнес эхлүүлэхэд дэмжлэг үзүүлдэг бөгөөд цаашид энэ чиглэлээр хамтран ажиллахаар судалж байна.

Е-7-4 визтэй ажлын байраа сольж ажил хайж буй иргэдэд дэмжлэг үзүүлэх чиглэлд БНСУ-ын Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих холбооны Гадаад мэргэжилтэн, ажилтныг дэмжих хэлтэстэй хамтран ажиллах санал солилцох уулзалтыг 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулж, тус байгууллагын веб сайт дээр холбоос үүсгэж, ажлын байр хайхад нь туслалцаа үзүүлэхээр тохиролцов.

Солонгос дахь КИМС хүүхэд хөгжлийн төвийн монгол талыг хариуцсан ажилтан Х.Нарантуяатай хүүхэд хөгжил болон нөхөн сэргээх чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцсон.

Илгээгч 17 орны хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлыг зохицуулагч субъект, төлөөлөгчийн газруудыг судлан, утсаар болон цахимаар холбогдож мэдээлэл бэлтгэсэн.

2. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хүний нөөцийг чадавхжуулах, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээ

3.2.1 Төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадвараа сайжруулах зорилтын хүрээнд төвийн албан хаагчид Солонгос хэлний сургалтад хамрагдаж байна. Хөдөлмөр, нийгмийн үйлчилгээний тасгийн албан хаагчдад “Олгогдоогүй цалин хөлсний маргаан, ажилтанд дэмжлэг үзүүлэх тогтолцоо”-ны талаар сургалт, ярилцлагыг зохион байгуулав. Мөн гамшгийн үед хэрэглэх материалын танилцуулга, ослын үед хэрэглэх цүнхэнд байх зүйлс, ослын үед авах арга хэмжээний талаар төвийн нийт албан хаагчдад мэдээлэл өгсөн.

3.2.2 Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын албан хаагчдын албан томилолтын бэлтгэл ажлыг хангаж, албан уулзалтуудыг зохион байгуулсан. Мөн төвийн 10 албан хаагчид 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр НҮБ-ын “Уур амьсгалын ногоон сан”-гийн үйл ажиллагаатай танилцсан бөгөөд харилцан төвийн чиг үүрэг, хэрэгжүүлж буй арга хэмжээ, үйл ажиллагаагаа танилцуулав. INSIDER TALK хэлэлцүүлгийн “Хараа хяналтгүй өсвөр насны хүүхдэд шаардлагатай нийгмийн хамгааллын үйлчилгээ” илтгэлийг сонсож, санал солилцсон. Сөүл хотын захиргааны гадаад ажилчдыг дэмжих төвөөс зохион байгуулсан гал түймэрт өртсөн бүс нутагт 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр Хөдөлмөр, нийгмийн үйлчилгээний тасгийн төлөөлөл очиж, хүмүүнлэгийн сайн дурын ажилд оролцсон.